



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 61

Сүхбаатар сум

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлан гаргасан
тогтоол, шийдвэр, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны
хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Орхонтуул, Баруунбүрэн, Сант, Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан гаргасан тогтоол, шийдвэр, аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнтэй танилцаад ТЭМДЭГЛЭХ нь:

Дээрх сумдад 2018 оны байдлаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт нэр заагдсан болон нийтлэг хамааралтай ажил, арга хэмжээний гүйцэтгэл дунджаар 80,3 хувьтай, сумдын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт 80,7 хувьтай байна.

Орхонтуул сум нь Засгийн газрын 131 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд анхаарч шаардлагатай арга хэмжээг авч ажилласнаар сүүлийн 3 жилийн байдлаар малын тоо, толгой 15,7 хувиар буурчээ.

Иргэдийг ажлын байраар хангах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр 2017 онд 50, 2018 онд 60 ажлын байрыг шинээр бий болгон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг 100 хувь хэрэгжүүлж ажилласнаас гадна малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 8 иргэнд 40 сая төгрөгийн үнэ бүхий малын дэмжлэг үзүүлсэн байна.

Баруунбүрэн сум нь 2018 онд иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд 38 иргэнийг нийт 83,0 сая төгрөгийн зээлд хамруулан ажлын байрыг нэмэгдүүлжээ.

Мөн Орхон аймгийн "Сүү-Эко" ХХК-тай гэрээ байгуулж ажилласнаар тус сумын 1,2 дугаар багийн 86 малчин өрх 89720 литр сүү худалдан борлуулж 40,1 сая төгрөгийн орлого олсон байна.

Сант сум нь иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр сум хөгжүүлэх сангаас 2017 онд нийт 10 иргэнд 45,5 сая төгрөгийн зээл олгон тухайн иргэдээс талхны болон годон гутлын цех байгуулан ажиллуулсан нь олон нийтийн таашаалд нийцсэн ажил болсон байна.

Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор фермерийн аж ахуйг дэмжин ажилласнаар нийт мал сүргийнхээ 11,0%-ийг цэвэр эрлийз мал болгожээ.

Орхон сум нь ажлын байр, өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр бүлгээр хөрзөн гишгэх, ямаа самнах ажилд иргэдийг татан оролцуулснаар нэг өрхийг дундажаар 200.000-600.000 төгрөгийн орлого олоход нь дэмжлэг үзүүлжээ.

“Монгол төмс” хөтөлбөрийн хүрээнд эрт ургацын “Солист” сортын төмсийг тариалан зах зээлд борлуулахад нь ихээхэн анхаарч ажилласнаар жилд дундажаар 100-150 иргэн эрт, дунд, оройн болцтой “Солист” сортын төмсийг тариалж 7-8 саруудад 2 тэрбум гаруй төгрөгийн борлуулалт хийн 1000 гаруй түр ажлын байрыг бий болгосон байна.

Мөн Шийрийн эрт ургацын төмсийг сурталчлах зорилгоор “Сэлэнгэ аймаг Шийрийн төмс нэртэй” 25.000 ширхэг шуудайг захиалгаар хийлгэн аж ахуйн нэгж, иргэдэд 5300 ширхэг шуудай хуваарилан өгч борлуулалтад дэмжлэг үзүүлжээ.

Үүнээс гадна зарим суманд аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй хэрэгжиж байна.

Тухайлбал: Баруунбүрэн, Сант суманд аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан гаргасан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулаагүй, иргэдийнхээ нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээгүй, Баруунбүрэн сум аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутагтаа хөрөнгө оруулалт татах тал дээр хангалтгүй ажилласан, Сант сум нь сум хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлогын бичиг баримт боловсруулж батлуулаагүй, сумын инженерийн шугам сүлжээг шинэчлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

Иймд дээрх сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан гаргасан тогтоол, шийдвэр, аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шинээр ажлын байр бий болгох замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хөрсний элэгдлийг бууруулах, үржил шимийг сайжруулах, мал, аж ахуйг эрчимжүүлэх, бэлчээрийн даацад тохирсон малтай байх чиглэлээр холбогдох арга хэмжээг авах, уул, уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарах, аялал жуулчлал, гадаад харилцааг хөгжүүлэх болон бусад асуудлуудын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай байгааг тэмдэглээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.2 дахь заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг: Аймгийн Засаг дарга Ш.Оргилд ДААЛГАХ нь:

1.Эвдэрч гэмтсэний улмаас ард иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх боломжгүй болсон Орхонтуул сумын Эрүүл мэндийн төвийн барилгын дээврийн засвар, Сайхан сумын Номгон тосгоны Эрүүл мэндийн төвийн барилгын засварын асуудлыг шуурхай судлан шийдвэрлэх;

2.Сайхан сумын “Гавшгай ус” ОНӨААТҮГ-ын алдагдлыг бууруулах, сумын цэвэр усны хангамжийг сайжруулах зорилгоор тус сумын нутаг дэвсгэрт гүний худаг гаргах хөрөнгийг ирэх оны аймгийн төсөвт суулгах боломжийг судлах;

3.Сум орон нутагт тулгамдаад буй хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлууд болох Баруунбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн агааржуулалтын засвар, Амарбаясгалант хийд дээр био “ОО” байгуулах, Орхон сумын Ерөнхий боловсролын сургуульд “Ухаалаг танхим” байгуулах, Сант сумын инженерийн шугам сүлжээний засвар, Сайхан сумын сум дундын эмнэлгийн их засварт шаардагдах хөрөнгө зардлуудыг улс, аймгийн төсөв болон гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт хамруулан шийдвэрлэх боломжийг судлах;

Хоёр: Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид болон Засаг даргад ДААЛГАХ нь:

1.Аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, ялангуяа хийгдээгүй удаашралтай байгаа ажил, арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх;

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас батлан гаргасан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн онцлогт тохирсон дэд хөтөлбөрийг боловсруулан хэлэлцэн баталж хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэх;

3.Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон сумын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн бусад бодлогын баримт бичгүүдийг боловсруулан баталж хэрэгжилтэнд нь хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах.

4. “Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолыг иргэд, малчдад сурталчлан таниулах, бэлчээрийн даацад тохирсон малтай байх зорилтын хүрээнд эрчимжсэн мал аж ахуйг дэмжих чиглэлээр бодлого барьж ажиллах;

5.Улс, аймгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сан, төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажилд тавих гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах;

Гурав:Орхонтуул сумын Засаг дарга П.Батбаатарт ДААЛГАХ нь:

1.Төрийн албан хаагч нарын ажиллах нөхцөл бололцоог сайжруулах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр бодитой ажил, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;

2.Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын хүрээнд гэрээ байгуулах замаар орон нутагт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх;

Дөрөв:Баруунбүрэн сумын Засаг дарга Г.Түмэн-Өлзийд ДААЛГАХ нь:

1.Аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар орон нутагт хийгдэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улмаар түүнд суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх;

2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд насанд хүрээгүй хүмүүсээс гэмт хэрэгт өртөх, гэмт хэргийн золиос болохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль хяналтын байгууллагатай хамтран тодорхой ажил, арга хэмжээнүүдийг зохион байгуулж үр дүнг тооцох;

3.Төрийн албан хаагчын нөхөн хангалтыг хийх ажлын хүрээнд шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч ажиллах;

4.Суманд хөнгөлөлттэй эмийн сан, нийтийн ахуйн үйлчилгээ байгуулах асуудлыг судлан нэн даруй шийдвэрлэх;

Тав:Сант сумын Засаг дарга Б.Буянхүүд ДААЛГАХ нь:

1.Аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар орон нутагт хийгдэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улмаар түүнд суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх,

2.Сум хөгжүүлэх сангаас олгож буй зээлийг жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих замаар иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд анхаарч ажиллах;

3.Хот, төлөвлөлт, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн баталж, хэрэгжүүлэх, инженерийн шугам сүлжээг сайжруулах чиглэлээр холбогдох зураг төслийг гарган шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлэх арга хэмжээг авах;


4.Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Малчдын зөвлөгөөн”-ийг хууль хяналтын байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах, мөн малчдын өөрсдийн сайн дурын үндсэн дээр “Малчдын бүлгэм” байгуулах ажлыг бодлогоор дэмжиж ажиллах;

5.Суманд хөнгөлөлттэй эмийн сан ажиллуулах асуудлыг нэн даруй судлан шийдвэрлэх;

Зургаа: Орхон сумын Засаг дарга Г.Бат-Орхонд ДААЛГАХ нь:

1. Цөлжилттэй тэмцэх, хөрс хамгаалах, үржил шимийг нь сайжруулах чиглэлээр бодит ажил, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;

2. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанар, орчинг сайжруулах, шаардлагатай мэргэжлийн багш нарыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боллоцоог ханган ажиллах;

ДАРГА  Г.БЯМБАА

